



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/62/-НА-СТА-ТШЗ

<b>Цахим хуудас:</b> <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр	
	Утас: 70483034	Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a>
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг	
	Утас: 70484030	Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор: Ж.Бүжинханд	
	Утас: 99177546	Цахим хаяг: <a href="mailto:Bujinkhandj@audit.gov.mn">Bujinkhandj@audit.gov.mn</a>
	Аудитор Г.Энхдэлгэр	
	Утас: 70484030	Цахим хаяг: <a href="mailto:Enkhdelgerg@audit.gov.mn">Enkhdelgerg@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан .....	8
3.1 Ерөнхий зүйл .....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Материаллаг байдал .....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	11
3.8 Аудитын гол асуудал .....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	11
4. Аудитын илрүүлэлт .....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	12

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА Д.ТУНГАЛАГ ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 65

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Засаг даргын дэргэдэх статистикийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Засаг даргын дэргэдэх статистикийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

07920243

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х. ТҮВШИНБАЯР



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,817,669.68</b>	<b>1,990,540.17</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	2,900,169.51	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	10,169.51	-
335	Бусад авлага	2,890,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	2,890,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	917,500.17	1,990,540.17
354	Хангамжийн материал	917,500.17	1,990,540.17
35410	Бичиг хэргийн материал	35,000.00	180,000.00
35420	Аж ахуйн материал	882,500.00	1,132,500.00
35440	Түлш, шатах тослох материал	0.17	678,040.17
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>33,079,587.34</b>	<b>33,390,662.92</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	33,079,587.34	33,390,662.92
392	Биет хөрөнгө	33,046,774.95	33,390,662.92
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	59,892,441.85	52,416,141.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,915,999.29)	(19,745,748.04)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,656,326.00	5,191,860.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,585,993.61)	(4,471,590.04)
393	Биет бус хөрөнгө	32,812.39	-
39301	Програм хангамж	433,750.00	433,750.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(400,937.61)	(433,750.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>36,897,257.02</b>	<b>35,381,203.09</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>-</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>36,897,257.02</b>	<b>35,381,203.09</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	36,897,257.02	35,381,203.09
512	Хуримтлагдсан үр дүн	36,897,257.02	35,381,203.09
51210	Өмнөх үеийн үр дүн	36,897,257.02	36,897,257.02
51220	Тайлант үеийн үр дүн	-	(1,516,053.93)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>36,897,257.02</b>	<b>35,381,203.09</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>446,028,089.00</b>	<b>318,735,583.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>22,628,881.00</b>	<b>10,661,200.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,344,900.00	10,661,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,344,900.00	10,661,200.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого үндсэн хөрөнгө	2,344,900.00	10,551,200.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого бараа материал	-	110,000.00
122	<b>Тусламжийн орлого</b>	20,283,981.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	20,283,981.00	-
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>423,399,208.00</b>	<b>308,074,383.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	97,890,500.00	107,050,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	97,890,500.00	107,050,300.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	325,508,708.00	201,024,083.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,365,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	325,508,708.00	199,659,083.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>416,950,954.91</b>	<b>320,251,636.93</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>416,950,954.91</b>	<b>320,251,636.93</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	393,693,013.02	305,969,024.11
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	171,480,233.76	165,490,575.60
210101	Үндсэн цалин	144,717,311.76	147,286,754.60
210102	Нэмэгдэл	18,675,600.00	13,918,033.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,060,530.00	3,062,780.00
210104	Урамшуулал	4,026,792.00	1,223,008.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	21,565,540.60	21,683,042.09
210201	Тэтгэврийн даатгал	14,681,873.16	21,683,042.09
210202	Тэтгэмжийн даатгал	993,903.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,595,714.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	989,279.44	-
210205	Эрүүл мэндийн даатгал	3,304,771.00	-
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	37,862,233.00	33,639,323.00
210401	Бичиг хэрэг	2,548,700.00	1,049,500.00
210402	Тээвэр, шатахуун	27,572,318.00	22,824,585.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,277,215.00	9,317,638.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	464,000.00	447,600.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,088,800.00	128,800.00
210604	Урсгал засвар	5,088,800.00	128,800.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	27,120,100.00	-
210702	Дотоод албан томилолт	27,120,100.00	-
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	121,928,666.00	74,573,859.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	117,836,966.00	73,226,759.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	137,600.00	137,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10,000.00	22,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,844,100.00	1,087,500.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,647,439.66	10,453,424.42
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,104,600.00	213,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	542,839.66	10,240,124.42
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	23,257,941.89	14,282,612.82
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	4,125,302.00	244,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,125,302.00	244,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	19,132,639.89	14,038,612.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,132,639.89	14,038,612.82
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>29,077,134.09</b>	<b>(1,516,053.93)</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>29,077,134.09</b>	<b>(1,516,053.93)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	5,432,065.16	5,432,065.16
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>5,432,065.16</b>	5,432,065.16
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	78,950,638.10	78,950,638.10
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>36,897,257.02</b>	36,897,257.02
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>36,897,257.02</b>	36,897,257.02
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>36,897,257.02</b>	36,897,257.02
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	(1,516,053.93)	(1,516,053.93)
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>35,381,203.09</b>	35,381,203.09

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>423,399,208.00</b>	<b>308,074,383.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>423,399,208.00</b>	<b>308,074,383.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>97,890,500.00</b>	<b>107,050,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	97,890,500.00	107,050,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>325,508,708.00</b>	<b>201,024,083.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,365,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	325,508,708.00	199,659,083.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>423,399,208.00</b>	<b>308,074,383.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>423,399,208.00</b>	<b>308,074,383.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>400,141,266.11</b>	<b>293,791,770.18</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>168,412,635.50</b>	<b>164,924,150.24</b>
210101	Үндсэн цалин	143,358,084.05	136,916,830.64
210102	Нэмэгдэл	17,119,300.00	20,851,864.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,734,528.02	3,466,671.65
210104	Урамшуулал	4,200,723.43	3,688,783.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>21,497,700.91</b>	<b>21,554,517.34</b>
210201	Тэтгэврийн даатгал	20,612,218.47	17,934,729.72
210202	Тэтгэмжийн даатгал	56,670.00	909,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,167.00	727,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	672,969.44	165,687.62
210205	Эрүүл мэндийн даатгал	141,676.00	1,817,900.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>30,507,453.00</b>	<b>33,028,563.00</b>
210401	Бичиг хэрэг	2,052,800.00	1,176,700.00
210402	Тээвэр, шатахуун	21,716,938.00	22,484,625.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,273,715.00	8,949,638.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	464,000.00	417,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,088,800.00</b>	<b>128,800.00</b>
210602	Тавилга	4,000,000.00	-
210604	Урсгал засвар	5,088,800.00	128,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>27,266,500.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	27,266,500.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>128,433,976.70</b>	<b>73,873,939.60</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	127,259,376.70	72,408,939.60
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	137,600.00	137,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10,000.00	22,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	927,000.00	1,205,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,934,200.00</b>	<b>281,800.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,934,200.00	281,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>23,257,941.89</b>	<b>14,282,612.82</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,125,302.00</b>	<b>244,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,125,302.00	244,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>19,132,639.89</b>	<b>14,038,612.82</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,132,639.89	14,038,612.82
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	Цэвэр гүйцэтгэл
		Батлагдсан төлөвлөгөө	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>107,050,300.0</b>	<b>103,748,072.96</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	107,050,300.0	103,748,073.0
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	106,806,300.0	103,504,072.96
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	90,897,000.0	88,336,757.84
210101	Үндсэн цалин	58,058,900.0	60,329,438.24
210102	Нэмэгдэл	23,691,700.0	20,851,864.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,579,200.0	3,466,671.65
210104	Урамшуулал	4,567,200.0	3,688,783.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтг.</b>	12,271,100.0	11,529,115.12
210201	Тэтгэврийн даатгал	8,635,200.0	7,909,327.50
210202	Тэтгэмжийн даатгал	909,000.0	909,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	727,200.0	727,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	181,800.0	165,687.62
210205	Эрүүл мэндийн даатгал	1,817,900.0	1,817,900.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,176,600.0	2,176,600.00
210401	Бичиг хэрэг	514,300.0	514,300.00
210402	Тээвэр, шатахуун	718,200.0	718,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	526,500.0	526,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	417,600.0	417,600.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	128,800.0	128,800.00
210604	Урсгал засвар	128,800.0	128,800.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төл</b>	1,051,000.0	1,051,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.0	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	137,600.0	137,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.0	22,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	791,400.0	791,400.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	281,800.0	281,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	281,800.0	281,800.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	244,000.00	244,000.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	244,000.0	244,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	244,000.0	244,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>107,050,300.0</b>	<b>103,748,072.96</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	107,050,300.0	103,748,072.96
131001	Улсын төсвөөс санхүүжих	107,050,300.0	103,748,072.96

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>201,024,083.0</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>201,024,083.0</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	190,287,697.22
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	76,587,392.40
210101	Үндсэн цалин		76,587,392.40
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	10,025,402.22
210201	Тэтгэврийн даатгал		10,025,402.22
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	<b>30,851,963.00</b>
210401	Бичиг хэрэг		662,400.00
210402	Тээвэр, шатахуун		21,766,425.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		8,423,138.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,</b>	-	<b>72,822,939.60</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр жураамж		72,408,939.60
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		414,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>10,736,385.78</b>
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>10,736,385.78</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		10,736,385.78
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>201,024,083.0</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>201,024,083.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,365,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	199,659,083.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхдэлгэр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 3 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь Статистикийн үйл ажиллагааны хараат бус бие даасан зарчмын дагуу нутаг дэвсгэрийн хэмжээнд төвлөрүүлэн үнэн бодитой чанартай мэдээлэл тооллого судалгаагаар хэрэглэгчдийг хангах чиг үүрэгтэй байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 185.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 8.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 6.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4 хувиар буюу 1.5 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гараагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2.0 сая төгрөг болж 1.1 сая төгрөгөөр өссөн нь шатахууны зарцуулалттай холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 48.0 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 47.1 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 2.0 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 58.0 сая төгрөг болж 7.9 сая төгрөгөөр буурсан нь 18.5 сая төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна. Тайлант онд 10.6 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 35.4 сая төгрөг болж 1.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 35.4 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 107.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 2 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 107.0 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 107.0 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 103.7 сая төгрөгийг зарцуулж 3.3 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 103.7 сая төгрөг буюу 97.0 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 2.6 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 0.7 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 201.0 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн

захирагчид хуваарилсан хөрөнгө 1.4 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 199.7 сая төгрөгийн орлогыг тайлагнасан. Үүнээс 10.7 сая төгрөгийг оны эцэст татан төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн орлогыг судлаач нарын цалин, судалгааны ажилд зарцуулжээ

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 140 мэдээллээс 140 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого мөнгөн гүйлгээг мэдээлсэн байна.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 14.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар тээвэр шатахууны зарцуулалтыг нарийвчлан үзэх нь зүйтэй.

### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 11.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.7 сая төгрөгийн алдааг залруулж, 10.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

#### **4.1 Залруулсан алдаа**

Аудитын явцад тайлант онд гарсан шатахууны зардлыг 0.7 сая төгрөгөөр илүү тайлагнасныг залруулсан.

#### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй.

#### 4.3 Албан шаардлага

Няrvын гаргасан шатахууны тайланг сар сараар тулган баталгаажуулахад жолоочийн тооцооны хуудас буюу бодит зарцуулалтаас 5,271.2 мянган төгрөгөөр илүү, 5,308.7 мянган төгрөгөөр дутуу зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.7-т "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн зөвлөмж хүргүүлээгүй.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс	2	11.3	1	0.7			1	10.6		

/сая төгрөгөөр/